

## 2003 ОНД ХИЙСЭН АРХЕОЛОГИЙН ХАЙГУУЛ СУДАЛГААНЫ ҮР ДҮНГЭЭС

Д.НАВААН

МУИС, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи-Археологийн тэнхим

**Түлхүүр үз:** Дорнод Монгол, монгол булш, хүнну булш, шоргоолжин булш

**ӨГҮҮЛЛИЙН ТОВЧ.** Энэхүү өгүүлэлд "Дорнод Монголын эртний иргэншил" төслийн хүрээнд 2003 онд хийгдсэн археологийн судалгааны үр дүнгээс толилуулж байна. Үг хээрийн судалгаагаар Хэнтий, Сүхбаатар аймгийн нутагт урьд өмнө судлаачдын хараанд өртөөгүй байсан Монголын түүхийн үе бурд холбогдох олон дурсгалыг шинээр илрүүлэн бүртгэж авсны дотор Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын Нууаарын цогцолбор дурсгал судлаачдын анхаарлыг татаж байна.

Антропологи-Археологийн хээрийн судалгааг 2003 оны VI сарын 15-наас VII сарын 13-ныг хүртэл 28 хоногийн хугацаагаар Хэнтий, Сүхбаатар аймгийн нутагт хийлээ.

Хээрийн судалгааны зорилго нь Дорнод Монголын нутагт байх монголын түүхийн янз бүрийн үед хамаарах археологийн зарим дурсгалуудтай танилцах, археологийн хайгуул, малтан шинжилгээ хийх, урьд өмнө тэмдэглэгдээгүй археологийн дурсгалыг олж илрүүлэх, малтан шинжлэхэд чиглэж байв.

Хээрийн судалгааны маршрут 3000 км: Улаанбаатараас Төв аймгийн Эрдэнэ, Баяндэлгэр, Багануур сумд, Хэнтий аймгийн Цэнхэрмандал, Дэлгэрхaan, Жаргалтхаан, Өмнөдэлгэр, Батширээт, Дадал, Биндэр, Баянхутаг сумд, Сүхбаатар аймгийн Мөнххаан, Түмэнцогт сумын нутгаар явж, эртний чулуун зэвсэг, хүрэл, төмөр, хүннү, хожуу нүүдэлчид, XIII зууны Монголын дурсгал хайж, археологийн малтлага хийж, зарим газар сорилт явуулав.

### ХЭНТИЙ АЙМАГ, ЦЭНХЭРМАНДАЛ СУМ

#### Цагаан морьтын ар

Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын нутаг, Хэрлэнгийн дээд гүүрнээс доош 10-аад км-т байх "Монголын нууц товчоон"- д дурьдсанаар Хэрлэн хөдөө арлын дэвсгэрт орох Хэрлэн Баян уулын салбар Цагаан морьтын нурууны ар бэлд XIII зууны нилээд булш илрүүлэн заримыг малтаж, монголын дундад зууны үеийн ховор материал илрүүллээ.

**Булш 1.** Газрын хөрсөн дээр умар зүг чиглэсэн цөөн дараас чулуу байсныг 4х6 м-ийн масштаб-д оруулан тэг татаж малтахад булшны нүх

илэрсэнгүй. Өнгөн хөрсийг хуулан цэвэрлэгээ хийхэд энд тэндээс хэдэн олдвор гарав. Үүнд: урт богино (7 ба 10 см) чөмөгтэй төмөр амгаа (XIII зуун), тарваганы эрүү, дунд чөмөг (хугархай), хурганы нүхэлсэн шагай здгээр болно. 40 см орчим гүнд малтлагын нүхний баруун хойд буланд шатсан хөрсний толбо, нүхний төв хэсэгт жижгэвтэр чулуун байгууламж гарав. 35x18 см хэмжээтэй, 4-5 см зузаан 4 хавтгай чулууг хажуу ирмэгээр нь бие биед нь тулган хашлага хийж дотор нь өөр нэгэн гурвалжин чулууг оройг дээш чиглүүлэн босоогоор тавьсан байлаа. Чулуун байгууламжаас доош 30 см малтахад эх газрын хөрс гарав. Энэхүү малтлагаас энд тахилга үйлдсэн гэж үзэв.

**Булш 2.** 1-р булшнаас зүүн тийш тэгш талд нилээд чулуу дугуйвтар хэлбэртэйгээр зохион байгуулалттай тавигдсан байв. Энэ нь хүүхдийн булш байж болох эсвэл мөн дээрхийн адил тахилга байж болох байв. Малтлагыг 4x5 метрийн харьцаатай татаж малтваас 30 см-ийн гүнд эх хөрс гарч ямар нэг эд өлөг, ваар, яс зэрэг гарсангүй. Үүнээс үзэхэд энэ сайхан шар энгэрт монгол хүн нас барсан хүнээ нутаглуулахад маш тохиромжтой атал, тахилга үйлдсэн байх нь Хэрлэн мөрөн, баруунаа орших сүрлэг их Мэлзээлэй уултай холбоотой болов уу гэсэн сэтгэгдэл төрж байв.

**Булш 3.** Энэ булш нь дээрх хоёр булшнаас хойш 500 м-т оршино. Хөрсөн дээрээ умар зүг чиглэсэн цөөн хэдэн чулуун өрлөгтэй байсан ба өнгөн хөрс хуулж авахад нилээн чулуу илэрч гарав. Уул малтлагыг 3x4 м-т тэг татаж малтхаар шийдэв. Малтлагын зүүн хэсэгт булшны нүх баймаар холилдмол хөрс гарч 50 см-ын гүнд хүний ганц шүд гарав. Үүнээс үүдэн малтлагын талбайг зүүн тийш 50 см өргөсгөн малтлаа. Энэ хэсэгт залуу хүний эрүү, дунд чөмөг, сүүж олдов. Толгой мөчдийн яс энд тэндээс эмх замбараагүй, анатомийн зохион байгуулалтгүй гарч байв. Их биеийн яс хадгалалт сайн боловч толгойн гавлын хэсэг олдсонгүй, хоншоор ясны үлдэгдэл маш муу хадгалагдсан 2 шүд олдлоо. Мөн хонь, ямааны хүзүү, ууц, мөчний яс тагалцаг олдлоо. Хүний араг ясны зүүн ташааны орчмоос төмөр цагираг жижиг төмөр гогцоо олдсон нь нум сумны тоног юм. Малтлага дуусахад булшны нүхний хэмжээ урт нь 2 м 10 см, өргөн 50 см, гүн 150 см болов.

## ХЭНТИЙ АЙМАГ, ЦЭНХЭРМАНДАЛ СУМ

### Нугаар

Энэ удаагийн экспедицээр Монгол овогтны уугуул нутаг Гурван голын сав газар, тухайлбал, Хэрлэн голын бүс нутаг, Хэрлэн хөдөө аралд хайгуул хийж, урьд өмнө археологийн судалгаа хийгээгүй газар нутаг усыг сурвалжлан

Хэрлэнгийн дээд гүүрнээс Хэрлэн, Баян Улааны өмнөд үзүүр хүртэл 128 км-т байх Нугаарын ам, хөндийд олон үеийн дурсгал шинээр илрүүлэн олсон болно. Бид тухайн нутгаар хайгуул хийж зарим газар археологийн малтлага явуулан, аль үеийн дурсгал зонхилж байгааг туршиж цаашид суурин судалгаа явуулах чиг тогтоолоо.

Хэрлэнгийн дээд гүүрнээс Хэрлэн баян улааны чиглэлд 20 гаруй км-т орших өргөн амыг Нугаар гэнэ. Энэ амны Хэрлэнд тулах хэсгийн бэсрэг толгойг уугуул нутгийн хүмүүс Зүүн байц, түүний баруун харалдааг Баруун байц гэнэ. Харин ирүүл айлууд Тариат гэнэ. Нугаарын өргөн тал хөндийд олон үеийн дурсгал, тухайлбал, хэрэгсүүр, хүрлийн үеийн дөрвөлжин булш, шоргоолжин булш, буган хөшөө, түрэгийн булш, хөшөө, 13-р зууны булш, Хүннүгийн булшууд байгааг хайгуулаар олж бүртгэн авлаа. Зүүн байцын өвөрт өвөлжөө, нэгэн дуган байсан ба оройд нь эртний булшны чулуугаар овоо босгосон байна. Энгэрээр хожуу нүүдэлчдийн нилээд булш ажиглагдлаа. Эдгээрээс нэгэн булш шилж сорилтын журмаар малтав.

**Булш 1.** Уул булш Зүүн байц хадны энгэрт умард зүг чиглэсэн чулуун өрлөгтэй өнгөн хөрсөн дээрх дараас чулуунууд зохион байгуулалтаар 13-р зууны булш байв. Анхны план зураг үйлдэж, гэрэл зураг авлаа. Малтлагын тэгийг 1.5x3 м-ээр авч, 160 см x 80 см булшны нүх гарав. Үргэлжлэн малтахад 120 см-ийн гүнд умар зүг харуулж оршуулсан хүний араг яс илрэв. Цэвэрлэн нарийвчлан нягтлахад нас барагчийн толгойн зүүн талд төлгөн хонины далыг маяаг дорогш харуулж тавьсан, зүүн гар дээр модон хуйтай төмөр хутга, 1 ширхэг төмөр зэв, баруун өвдөгт хонины шаант чөмөг, ууцан дор хонины нурууны нугалмай хоёр, саадагны үйсэнд зэвгүй мөс байв. Нас барагчийн араг яс нэлээд сайн хадгалагдсан байв.

Булш 1 -ээс олдсон олдворыг XIII зуунд хамааруулж болохыг зан үйлийн зарим баримтаар нотолж байна. Үүнд:

1. Булш 1-ийн нас барагч бол арав гаруй насны хүүхэд (эрэгтэй) бөгөөд оршуулах зан үйлийн хэд хэдэн шинжийг хадгалж байна. Нас гүйцээгүй боловч оршуулсан газар нь нар ээх сайхан энгэр газар монгол хүний зан заншил баримталж толгойг хойш харуулж, тэнэгэр байдлаар зан үйлийн холбогдох зүйлсийг дагалдуулсан байна.

2. Дагалдуулсан эд өлгийн шинжээр бол эрийн цээнд хүрээгүй тул хүүхэд насны хэмжээнд тохируулан залуу нас шүд гүйцээгүй төлгөн хонины дал, шагайт чөмөг зөвхөн хоёр нуруу (нас гүйцсэн хүнд журам мэт гурван нурууг

тавьсан байдаг) ууцан дор нь ёсолсон сонирхолтой баримт гэж үзэж болно. Мөн шагай чөмгийг толгойн дээд хажууд тавьсан байдаг байхад баруун өвдөгт байлуулсан явдал зан үйлийн нэг өөр хэлбэр гэж хэлж болно.

3. Нэг ширхэг төмөр зэв тавьж саадагны үйсэнд зэвгүй сумны мөсний хугархай ёсолсон нь нас барагч цэрэг эрийг насанд хүрээгүй боловч ирээдүйд эр цэрэг болно гэдгийг бэлэгдсэн байв. (XIII зууны нас бие гүйцсэн хүнд гурван өөр төмөр зэв, ихэнх тохиолдолд хүлэг сайн морины эмээл хазаарын хэрэгсэл, дөрөө, амгаа, зуузай дагалдуулсан байдаг билээ).

### **Нугаарын хөндийд хайгуул хийсэн тухай**

Өвөг түүхийн олон үеийн дурсгалтай Хэрлэн мөрний энэ хавь Зүүн байц орчимд эртний чулуун зэвсэг хийхэд зориулсан түүхий эд материал – томируун үлдэц (Нуклеус), неолитийн залтас, мөн Ноён уулын Хүннүгийн булш байгаа газраас гарсан тэнгийн цөгцтэй адилавтар ширмэн цөгц олдож байлаа.

Энд дор дурдсан түүх соёлын дурсгалуудыг бүртгэн тэмдэглэж авлаа.  
Үүнд:

- ❖ 16,5 м хөндлөн огтлол бүхий овоо чулуун булш (Хиргисхүүр гэж нэрлэсээр ирсэн дурсгал), түүнийг тойрсон олон янзын дөрвөлжин булш, баруун талд нь 5,7x9 м, 6x8,2 м хэмжээтэй дараас бүхий булш байгууламж, 3,4x2,3 м, 2x2,7 м хэмжээ бүхий дөрвөлжин булш
- ❖ 1 м орчим өндөртэй хүрлийн үеийн буган чулуун хөшөө. Уг хөшөө унасан байсныг бид босгон байрлуулав.
- ❖ Эртний Түрэгийн (IV-VIII зуун) хэд хэдэн төрөл дурсгал (4-т, 5-т, чулуун хайрцагт, зэл чулуут) булш, хөшөө.

VI-VIII зуунд холбогдох эртний Түрэгийн 4-т, 5-т хэмээх дөрвөлжин чулуун хашлага бүхий булш нь ихэвчлэн хүнээ чандарлан ёсолсон тохиолдох ба адуу, үхэр зэрэг бод, хонь, ямаа зэрэг богийн яс, шатсан нүүрс, үнс, жижиг ваар сав хагархай олддог. Зарим тохиолдолд Түрэгийн 5-т, 4-т булшинд нар ургах зүг харуулан хүн хөшөө босгож гол чулуун хайрцаг (хашлага)-д алтан эдлэл дагалдуулсан буй (Наваан, 2004). Тухайлбал, Хэнтий аймгийн Хэнтий сумын (хуучнаар) өргөө чулууны булш (Гурван голын шинжилгээний ангийн тайлан, 1966; Гурван голын шинжилгээний ангийн тайлан, 1969), мөн Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Наймаа толгойн булшинд хазаарын амгаа, төмөр дөрөө (Монгол-Унгарын хамтарсан экспедицийн тайлан, 1971) ёсолсон

байв. Эдгээр булштай адил зохион байгуулалт бүхий булш Нугаарын аманд хэд хэд хайгуулаар илэрч олдсон юм.

- ❖ Ойрхон нэр нь үл мэдэгдэх ууланд бүлэг булш зэрэг олдсон байна.

Энэ бүхнээс үзэхэд Хэрлэн хөдөө арал, Хэрлэн Баян Улааны орчин бол олон зуу, мянган жилийн өвөг түүх, XIII зууны монголын үүх түүхээ хөрс шороондоо хадгалж үлдсэн түүхийн алтан өлгий мөн билээ. Үүний дотор судалгааны хүрээнд ороогүй, тэр тусмаа нэгэн дор түүхийн үе үеийн дурсгал цогцолсон Нугаарын хөндий аргагүй судлаачдын анхаарлыг татаж байна. Нугаарын хөндийд болон ойр орчимд байгаа олон үеийн дурсгалыг нэг бүрчлэн иж бүрэн судлах, археологийн малтлага явуулан, урьд өмнө судалгааны хүрээнд ороогүй газрын шинэ тулгар судалгааны материал, эд өлгийн дурсгалыг эрдэм шинжилгээний гүйлгээнд оруулан үр дүнгээ хэлэлцэх нь Азийн судлал төслийн хүрээнд үргэлжлүүлэн явуулах судалгааны нэг чиглэл байх болно.

### **ХЭНТИЙ АЙМАГ, ДЭЛГЭРХААН СУМ**

#### **Аураг балгас, Рашаан дэрс**

Дэлгэрхаан сумын нутагт Хэрлэн Баян Улааны нөсөр их уулсын хэдэн арван ам, хөндий, тал хээр, дов толгод, булаг шанд, рашаан, ус байх бөгөөд Аврага тосонгийн 2 нуур Аврагын рашааныг дотор өвчинд эмчилгээний зориулалтаар эртнээс нааш ашигласаар иржээ. Байгалийн баялаг Өгөөжийг түшиглэн XIII зууны Монгол улсын дундад үеийн Чингисийн бага орд хэмээх Аураг балгас энд байгуулагдан Чингис хааны авааль хатан Бөртэ үжин сууж байсан гэдэг юм. Чингээд ч 1240 онд "... Хэрлэн хөдөө арал Долоон болдог, (одоогийн "Долоод" гэх долоон толгод) Шилхэнцэг хоёрын хооронд хааны хотыг буujж байхад Монголын нууц товчоон бичиж төгсөв ..." (Монголын нууц товчоо, 1947, 280-р тал 282 зүйл) гэсэн байдаг.

Аураг балгас орд суурьшил болон нүүдлийн соёл иргэншлийн тал талын дурсгал хадгалсан, тухайн үед их хөл хөдөлгөөнтэй, гар үйлдвэр, төмөр боловсруулах цех, худалдааны төв, гэрийн хороололтой, XIII зууны монголын түүхэнд чухал байр суурьтай газар байсныг бидний хийсэн хайгуулаар олдсон түүвэр олдворууд (Алтан улсын үеийн зоос, төмөр эдлэлийн хэсэг, нумын ясан наалт болон бусад ясан болон гуулин эдлэлүүд) гэрчилнэ.

Аураг балгас, Рашаан дэрсний орчим бид хүрлийн үед хамаарах шоргоолжин булш малтав.

**Шоргоолжин булш.** Рашаант толгойн оройд эртний ганц булш байгааг малтсан бөгөөд хүрэл зэвсгийн үеийн дөрвөлжин булшны өөр хэлбэр шоргоолжин булш байлаа. Булшны чулууны өрлөг нар гарах зүг толгой талаараа чиглэж байв. Уул булшны зураг 15, ерөнхий урт 7 м байв. Урьдын туршлагаас дараасын өмнө бууринд хүнээ оршуулсан тохиолдол байсан тул сорилтын малтлага хийв. Дараас чулууг хуулан авахад 50-60 см гүнд тэнэгэр байдалтай араг яс гарав. Mash эртний булш гэхэд ус тогтохгүй газар тул эртний хүний олдвор нилээд сайн хамгаалттай байв. Араг ясны дэргэд ямар нэгэн эд өлгийн дурсгал байсангүй.

Аураг балгасны ойр орчимд гүйцэтгэсэн өөр сэдэв бол хайгуул байв. Рашаант толгойн зүүн үргэлжлэл өмнө хойд ухаагаар хотын оршин суугчдын 4-6 ширхэг жирийн булш байв. Мөн Хар нүдэнгийн талд зүүн хойшлоод бүлэг дөрвөлжин булш, хүн чулуун хөшөө олддог.

### **ХЭНТИЙ АЙМАГ, ЖАРГАЛТХААН СҮМ**

#### **Дуулга уул**

Дуулга уулын бүлэг булшийг анх Хэнтий аймгийн орон нутаг судлах музейн эрхлэгч Жүгдэржав мэдээлж, 1968 онд Д.Наваан, Х.Пэрлээ нар анх удаа малтлага хийсэн. Үүний дараа Монгол, Унгарын хамтарсан анги 1971-1981 онд, ШУА-ын Түүхийн хүрээлэн (археологич Д.Баяр), МУИС-ийн Антропологи-археологийн анги 2 жил дараалан малтлага хийж байгаа юм (МУИС, НШУС-ийн Антропологи - археологийн тэнхмийн хээрийн дадлагын тайлан, 2002; МУИС, НШУС-ийн Антропологи - археологийн тэнхмийн хээрийн дадлагын тайлан, 2003).

Энд бид бүлэг булшны баруун хойд захад орших зэрэгцээ 2 булшийг сонгон дараас чулууны зураг үйлдэж малтах ажилд оров.

**Булш 1.** Баруун талаас 4 метр өргөнтэй малтахад булшний нүхний булан 2 м өргөнтэй тодров. Ийнхүү нүхний дагуу гүнзгийлэхэд 3,5 м гүнд энд тэндээс ваарны хагархай, хүний яс, адууны хавирга, үйсэн эдлэлийн хэлтэрхий, даавууны өөдөстэй модны хэсэг гарч 4 м-т булшны нүх дуусав. Булшны нүхний байдлаар хүнээ баруун өмнө зүг харуулсан нь Хүннүгийн нийтлэг зан үйлээс гажууд байв.

**Булш 2.** Нэгдүгээр булшны баруун урд байрлах ба хөндлөн огтлолоор өмнөх булштай адил байв. Хөрсөн доорх чулууны дараас нь өмнө баруун урьд талд овоорсон тул эрт тоногдсон шинж илэрхий байв. Малтлагыг 16x20 м тэг татаж баруун захаас 12 м өргөн хэмжиж малтахад булшний нүх гурван метр гүнд тодров. Хүнээ 40 см, 180 см австай оршуулсан бололтой байв. Энэ

булшнаас хүний өсгийний яс, малын яс, том жижиг ваарны хагархай, маш муудаж өмхөрсөн бугын эвэр гарч, өөр эд өлгийн дурсгал гарсангүй. Гал түлж хиншүүлсэн хар хөө, тортогтой хэсэг олдсон болно. Хүний дэргэдээс олдсон шагайт чөмөг, сүүж дал зэрэгт зэсийн ногоон зэв шингэсэн нь ямар нэг эд өлгийн зүйл байсныг тонуулчид авсан бололтой.


Энэ жил явуулсан хээрийн судалгааны ажил нь Монгол овогтны төр улсаа цогцлон байгуулж байсан гурван мөрний сав газар, нэн ялангуяа дундад зууны Монголын түүхийн алдарт дурсгал Монголын нууц товчооны түүхэн газар нутаг – Хэрлэн хөдөө аралын цар хүрээнд хайгуул малтлагын ажил явуулж олон арван шинэ тулгар материал илрүүлэн олсноор эрдэм шинжилгээ судалгааны чухал ач холбогдолтой болсон юм. Хэнтий, Сүхбаатар, Дорнод аймгийн нутагт Монголын түүхийн үе бүрд холбогдох хэдэн зуун дурсгалыг сүүлийн жилүүдэд шинээр илрүүлэн бүртгэж авснаас (Монгол-Америкийн хамтарсан “Чингис хаан” экспедицийн тайлан, 2002) үзэхэд тус бүс нутгийн антропологи, археологийн гүнзгийрүүлсэн судалгаа нь эрдэм шинжилгээний хувьд ихээхэн ирээдүйтэй болох нь харагдаж байна.

## ТАЛАРХАЛ


2003 онд МУИС-ийн Антропологи-Археологийн тэнхмээс Дорнод Монголын эртний иргэншлийн судалгаа явуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн МУИС-ийн Азийн Судалгааны Төв (ARC), Солонгос улсын Ахисан шатны судалгааны санд (KFAS) талархал илэрхийлье.

## НОМ ЗҮЙ


- Гурван голын шинжилгээний ангийн тайлан, 1966
- Гурван голын шинжилгээний ангийн тайлан, 1969
- Монгол-Америкийн хамтарсан “Чингис хаан” экспедицийн тайлан, 2002.
- МЗТСХЭ-ийн тайлан, 1984
- МУИС, НШУС-ийн Антропологи, археологийн тэнхимиийн хээрийн дадлагын тайлан, 2002
- МУИС, НШУС-ийн Антропологи, археологийн тэнхимиийн хээрийн дадлагын тайлан, 2003
- Монгол-Унгарын хамтарсан экспедицийн тайлан, 1971
- Монголын нууц төвчоо, 1947 (монгол бичгээр)
- Наваан Д., 2005. Археологийн алт эрдэнэсийн дурсгал.



Хэнтий аймаг. Цэнхэрмандал сум.  
Цагаан морьтын ар.  
Булш 1.



Хэнтий аймаг. Цэнхэрмандал сум.  
Цагаан морьтын ар.  
Булш 1. Чулуун байгууламж



Хэнтий аймаг, Цэнхэрмандал сум.  
Цагаан морьтын ар.  
Булш 1. Төмөр амгаа

2003 онд хийсэн археологийн хайгуул судалгааны дүнгэс



Хэнтий аймаг. Цэнхэрмандал сум.  
Нугаар. Булш 1.




Хэнтий аймаг. Цэнхэрмандал сум.  
Нугаар. Хэрэгсүүр



Хэнтий аймаг. Цэнхэрмандал сум.  
Нугаар. Дөрвөлжин булш



Хэнтий аймаг. Цэнхэрмандал сум.  
Нугаар. Дөрвөлжин булш




Хэнтий аймаг. Цэнхэрмандал сум. Нугаар.  
Түрэгийн үеийн дурсгал



Хэнтий аймаг. Цэнхэрмандал сум.  
Нугаар. Буган чулуу

2003 онд хийсэн археологийн хайгуул судалгааны дүнгээс



Хэний аймаг. Цэнхэрмандал сум.  
Нугаар. Буган чулуу

#### НУГААРААС ОЛДСОН ТҮҮВЭР ОЛДВОР




Ширмэн цөгц



Нуклеус




Хэнтий аймаг. Дэлгэрхaan сум.  
Рашаан толгой.  
Булш 2. Эртний хүний олдвор



Хэнтий аймаг. Жаргалтхаан сум.  
Дуулга уул  
Булш 1. Гадаад зохион байгуулалт



Хэнтий аймаг. Жаргалтхаан сум.  
Дуулга уул  
Булш 2. Гадаад зохион байгуулалт



Хэнтий аймаг, Жаргалтхаан сум.

Дуулга уул.

Булш 2. Бугын эвэр

#### SUMMARY

*D.Navaan*

#### THE RESULTS OF THE ARCHAEOLOGICAL SURVEY IN EASTERN MONGOLIA, 2003

Field study carried out in 2003 uncovered numbers of interesting artifacts, important for the study of burial ritual of middle ancient Mongolian and will provide a more compleate understanding of ancient Mongolians' culture and origin. Newly discovered site in Tsenhermandal soum, Khentii aimag requires intensive archaeological and anthropological survey in the region.